

СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Эрүүл мэндийн газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СБА-2025/070/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Баруун-Урт сум

2025 он

Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Г.Даваа

Утас: 70518396

Цахим хаяг: Davaag@audit.gov.mn

Аудитын менежер: М.Нарантуяа

Утас: 99029193

Цахим хаяг: Narantuyam@audit.gov.mn

Аудитор: А.Мөнхцэцэг

Утас: 70512123

Цахим хаяг: Munkhtsetsega@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	14
4.1 Ерөнхий зүйл	14
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.5.1 Завсрын аудитын талаар	15
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

6 дивизарт, Нутгийн удирдлагын 2 дугаар байр,
Балдан Осорын гудамж, 7 дугаар байр,
Баруун-үргэ сум, Сүхбаатар аймаг, 22079
Утас: (976) 70516396
Цахим шуудан: sukhbaatar@audd.gov.mn

2025.08.25 № 126

танил _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрүүл мэндийн газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд өрхийн эмнэлгийн барилга ашиглалтад орж, тээврийн хэрэгсэл нэмэгдсэнээр үндсэн хөрөнгө 1,760,258.2 мянган төгрөгөөр буюу 2.2 дахин өссөн бөгөөд энэ нь иргэдэд эрүүл мэндийн үйлчилгээг хүртээмжтэй, тав тухтай орчинд хүргэх боломжийг бүрдүүлж, салбарын дэд бүтцийн хөгжилд эерэг нөлөө үзүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Барилгын засаарын дансанд тусгай зориулалтын материалыг буруу ангилан бүртгэсэн зөрчлийг илрүүлж, холбогдох журам болон стандартад нийцүүлэн залруулж, зөв ангилалд бүртгүүлэн, санхүүгийн тайлангийн үр нөлөөг дээшлүүлсэн.

Бусад асуудал

"Эрүүл мэндийн үйлчилгээнд тавигдах шаардлага" MNS 7014:2023 стандартыг эрүүл мэндийн байгууллага бүрд хэвшүүлэх, сурталчлах зорилгоор 9 удаагийн сургалт зохион байгуулж 19 байгууллагын давхардсан тоогоор 511 эмч эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан хамрагдсан.

Тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Г.ДАВАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>428,335,286.51</u>	<u>303,349,264.39</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	2,300,000.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	2,300,000.00
3121	Төгрөг	00.00	2,300,000.00
31211	Төрийн сангийн харилцах	00.00	2,300,000.00
33	АВЛАГА	<u>59,582,034.00</u>	<u>4,201,500.00</u>
335	Бусад авлага	59,582,034.00	4,201,500.00
3351	Байгууллагаас авах авлага	59,160,534.00	3,780,000.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	421,500.00	421,500.00
35	БАРАА МАТЕРИАЛ	<u>368,753,252.51</u>	<u>296,847,764.39</u>
351	Түүхий эд материал	139,057,586.52	153,803,921.90
35110	Тусгай зориулалттай материал	136,557,313.56	151,333,618.34
35130	Эм боох материал	2,500,272.96	2,470,303.56
35300	Бэлэн бүтээгдэхүүн	54,016,206.28	34,187,555.78
354	Хангамжийн материал	172,647,459.71	108,856,286.71
35410	Бичиг хэргийн материал	1,138,000.00	1,204,500.00
35420	Аж ахуйн материал	69,739,966.31	75,308,579.31
35440	Түлш, шатах тослох материал	1,860,433.00	3,383,833.00
35450	Барилгын засварын материал	94,581,942.40	24,644,756.40
35470	Бусад хангамжийн материал	5,327,118.00	4,314,618.00
35600	Мал амьтад	3,032,000.00	00.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,499,337,852.34</u>	<u>3,259,596,101.58</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	<u>1,499,337,852.34</u>	<u>3,259,596,101.58</u>
392	Биет хөрөнгө	1,416,229,452.34	3,176,687,701.54
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,063,393,773.38	2,856,587,428.38
39202	Хуримтлагдсан элэгдэл	-86,615,502.12	-122,312,001.73
39203	Авто-тээврийн хэрэгсэл	207,460,000.00	386,060,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-123,682,222.37	-194,175,555.81
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	401,866,720.80	395,995,308.39
39206	Хуримтлагдсан элэгдэл	-97,640,292.38	-186,362,355.16
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	98,079,550.00	97,955,115.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-46,997,974.97	-57,425,637.53
39217	Ном	365,400.00	365,400.00
393	Биет бус хөрөнгө	<u>83,108,400.00</u>	<u>82,908,400.04</u>
39301	Програм хангамж	300,000.00	300,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-199,999.96
39303	Бусад биет бус хөрөнгө	82,808,400.00	82,808,400.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,927,673,138.85</u>	<u>3,562,945,365.97</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>00.00</u>	<u>95,584,320.52</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	<u>00.00</u>	<u>95,584,320.52</u>
413	Өглөг	00.00	95,584,320.52
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	20,170,320.52
4136	Бусад өглөг	00.00	75,414,000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	00.00	75,414,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,927,673,138.85</u>	<u>3,467,361,045.45</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,927,673,138.85	3,467,361,045.45

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	499,543,519.23	499,543,519.23
51101	Өмч: - төрийн	499,543,519.23	499,543,519.23
512	Хуримтлагдсан үр дүн	1,363,714,238.71	2,903,617,145.31
51210	Өмнөх үеийн үр дүн	1,363,714,238.71	1,363,929,238.71
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	1,539,687,906.60
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	64,415,380.91	64,200,380.91
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,927,673,138.85</u>	<u>3,562,945,365.97</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,971,102,607.28	5,312,409,667.93
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	854,766,280.28	2,525,307,958.67
120	Нийтлэг татварын бус орлого	854,766,280.28	2,525,307,958.67
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	854,766,280.28	2,525,307,958.67
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,116,336,327.00	2,787,101,709.26
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,960,832,700.00	2,506,539,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,960,832,700.00	2,506,539,700.00
	Төсөвт байгууллагын өөрийн орлого	854,766,280.28	553,514,303.67
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материал	00.00	553,514,303.67
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан Үндсэн хөрөнгө	00.00	1,971,793,655.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	24,766,474.00	79,347,572.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	26,602,629.00	100,807,237.26
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	70,909,424.00	95,181,600.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	33,225,100.00	5,225,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4,324,724,190.21	3,770,461,378.85
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,324,724,190.21	3,770,461,378.85
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,235,820,348.05	2,482,198,916.48
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	654,609,696.19	1,032,906,182.78
210101	Үндсэн цалин	407,524,687.72	632,871,030.88
210102	Нэмэгдэл	125,794,102.83	226,788,752.14
210103	Унаа хоолны хөнгөлөлт	31,538,328.36	77,126,507.70
210104	Урамшуулал	89,752,577.28	96,119,892.06
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	84,508,048.69	127,957,112.93
210201	Тэтгэврийн даатгал	57,814,745.73	87,668,812.93
210202	Тэтгэмжийн даатгал	6,710,355.25	10,072,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,350,464.20	5,036,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,330,453.05	5,036,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	13,302,030.46	20,144,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	78,734,296.98	87,765,646.15
210301	Гэрэл, цахилгаан	6,168,630.98	14,800,880.15
210302	Түлш, халаалт	63,216,230.00	63,750,478.00
210303	Цэвэр, бохир ус	9,349,436.00	9,214,288.00
2104	Хангамж, бараа материалын зардал	146,010,333.99	153,160,624.87
210401	Бичиг хэрэг	4,393,600.00	8,652,000.00
210402	Тээвэр, шатахуун	29,201,340.91	111,371,212.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,641,168.48	4,824,491.55
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал,	135,000.00	180,000.00

	ариутгал		
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	101,372,337.60	13,782,161.00
210408	Бараа материал акталсны зардал	7,266,887.00	14,350,760.32
2105	Нормативт зардал	997,881,393.66	656,854,507.47
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	997,881,393.66	656,854,507.47
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	35,840,355.00	37,943,052.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	2,017,152.00
210604	Урсгал засвар	35,840,355.00	35,925,900.00
2107	Томилолт, зочны зардал	24,964,700.00	56,885,200.00
210702	Дотоод албан томилолт	24,964,700.00	56,885,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,400,519.50	8,879,112.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,722,107.50	4,288,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	1,618,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	120,060.00	100,560.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,270,000.00	1,841,000.00
210807	Газрын төлбөр	233,352.00	953,352.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	00.00	45,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	206,871,004.04	319,847,478.28
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,368,673.00	13,303,695.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	43,809,570.00	95,820,860.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	148,692,761.04	210,722,923.28
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,088,903,842.16	1,288,262,462.37
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,817,685,849.00	1,132,788,400.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	984,839,104.00	569,949,700.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	828,224,900.00	546,198,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,621,845.00	16,640,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	271,217,993.16	155,474,062.37
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	271,217,993.16	155,474,062.37
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-353,621,582.93	1,541,948,289.08
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	33,712,793.10	2,260,382.48
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	25,743,793.10	2,260,382.48
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	7,969,000.00	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-33,712,793.10	-2,260,382.48
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-387,334,376.03	1,539,687,906.60

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	3,137,819,508.00	2,846,262,243.26
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,137,819,508.00	2,846,262,243.26
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,960,832,700.00	2,506,539,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,960,832,700.00	2,506,539,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	176,986,808.00	339,722,543.26
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	24,766,474.00	79,347,572.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	30,802,629.00	100,807,237.26

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	75,909,424.00	95,181,600.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	45,508,281.00	64,386,134.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	3,132,819,508.00	2,842,514,343.26
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,132,819,508.00	2,842,514,343.26
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	984,757,938.84	1,625,885,880.89
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	654,609,696.19	1,012,831,862.26
210101	Үндсэн цалин	407,524,687.72	612,796,709.96
210102	Нэмэгдэл	125,794,102.83	226,788,752.54
210103	Унаа хоолны хөнгөлөлт	31,538,328.36	77,126,507.70
210104	Урамшуулал	89,752,577.28	96,119,892.06
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	84,508,048.69	127,957,112.93
210201	Тэтгэврийн даатгал	57,814,745.69	87,668,812.93
210202	Тэтгэмжийн даатгал	6,710,355.25	10,072,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,350,464.20	5,036,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,330,453.05	5,036,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	13,302,030.50	20,144,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	78,687,096.98	87,057,246.15
210301	Гэрэл, цахилгаан	6,123,630.98	14,800,880.15
210302	Түлш, халаалт	63,216,230.00	63,750,478.00
210303	Цэвэр, бохир ус	9,347,236.00	8,505,888.00
2104	Хангамж, бараа материалын зардал	35,824,343.48	126,516,368.55
210401	Бичиг хэрэг	3,682,600.00	9,375,100.00
210402	Тээвэр, шатахуун	25,418,474.00	107,961,850.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,712,889.48	4,824,491.55
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	180,000.00	180,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,830,380.00	4,174,927.00
2105	Нормативт зардал	1,983,800.00	57,373,500.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,983,800.00	42,781,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	14,592,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	35,443,655.00	36,161,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	902,800.00
210604	Урсгал засвар	35,443,655.00	35,258,600.00
2107	Томилолт, зочны зардал	24,644,700.00	56,885,200.00
210702	Дотоод албан томилолт	24,644,700.00	56,885,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,330,998.50	9,329,112.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,724,307.50	4,288,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	1,618,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	120,060.00	100,560.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,198,279.00	2,291,000.00
210807	Газрын төлбөр	233,352.00	953,352.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	00.00	45,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	62,725,600.00	111,774,079.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,399,833.00	14,787,897.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	49,325,767.00	96,986,182.00

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,148,061,569.16	1,216,628,462.37
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,817,683,042.00	1,057,374,400.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	984,839,104.00	569,949,700.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	828,224,900.00	470,784,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,619,038.00	16,640,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	330,378,527.16	159,254,062.37
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	159,254,062.37
213304	Хөрөнгийн	330,378,527.16	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	5,000,000.00	3,747,900.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	5,000,000.00	1,447,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,000,000.00	1,447,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	5,000,000.00	1,447,900.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	5,000,000.00	1,447,900.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-5,000,000.00	-1,447,900.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	2,300,000.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	2,300,000.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	499,543,519.23	64,415,380.91	1,363,714,238.71	1,927,673,138.85
D01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	499,543,519.23	64,415,380.91	1,363,714,238.71	1,927,673,138.85
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	215,000.00	215,000.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	499,543,519.23	64,415,380.91	1,363,929,238.71	1,927,888,138.85
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-215,000.00	00.00	-215,000.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	1,539,687,906.60	1,539,687,906.60
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	499,543,519.23	64,200,380.91	2,903,617,145.31	3,467,361,045.45

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,506,539,700.00	2,355,782,119.09
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,506,539,700.00	2,355,782,119.09
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,314,679,600.00	1,302,307,719.09
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	962,207,100.00	962,207,100.00
210101	Үндсэн цалин	597,644,800.00	562,171,947.70
210102	Нэмэгдэл	227,952,700.00	226,788,752.54
210103	Унаа хоолны хөнгөлөлт	56,976,500.00	77,126,507.70
210104	Урамшуулал	79,633,100.00	96,119,892.06

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	129,300,800.00	123,451,507.39
210201	Тэтгэврийн даатгал	89,012,500.00	83,163,207.39
210202	Тэтгэмжийн даатгал	10,072,200.00	10,072,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,036,000.00	5,036,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	5,036,000.00	5,036,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	20,144,100.00	20,144,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	81,768,400.00	79,048,384.15
210301	Гэрэл, цахилгаан	7,620,400.00	6,792,018.15
210302	Түлш, халаалт	49,970,200.00	63,750,478.00
210303	Цэвэр, бохир ус	24,177,800.00	8,505,888.00
2104	Хангамж, бараа материалын зардал	50,834,200.00	49,060,418.55
210401	Бичиг хэрэг	4,333,200.00	4,761,000.00
210402	Тээвэр, шатахуун	39,728,800.00	35,120,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,404,000.00	4,824,491.55
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	419,100.00	180,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,949,100.00	4,174,927.00
2105	Нормативт зардал	17,385,700.00	17,375,500.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,208,400.00	2,783,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	14,177,300.00	14,592,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	29,234,500.00	27,609,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	916,600.00	1,330,700.00
210602	Тавилга	1,500,000.00	1,020,000.00
210604	Урсгал засвар	26,817,900.00	25,258,600.00
2107	Томилолт, зочны зардал	20,015,200.00	19,985,200.00
210702	Дотоод албан томилолт	20,015,200.00	19,985,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,917,700.00	7,829,112.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,795,800.00	2,788,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,623,100.00	1,618,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	144,200.00	100,560.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	42,300.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,292,200.00	2,291,000.00
210807	Газрын төлбөр	972,500.00	953,352.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	47,600.00	45,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16016000.00	15741197.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,061,400.00	14,787,897.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	954,600.00	953,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1191860100.00	1053474400.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,191,860,100.00	1,053,474,400.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	701,894,100.00	569,949,700.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	477,219,200.00	470,784,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,746,800.00	12,740,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,506,539,700.00	2,506,539,700.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,506,539,700.00	2,506,539,700.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,506,539,700.00	2,506,539,700.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	40	38
620001	Удирдах ажилтан	4	6
620002	Гүйцэтгэх ажилтан	29	23
620003	Үйлчлэх ажилтан	7	9

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	328,926,061.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	328,926,061.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	325,026,061.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	50,624,762.26
210101	Үндсэн цалин	50,624,762.26
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,505,605.54
210201	Тэтгэврийн даатгал	4,505,605.54
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,008,862.00
210301	Гэрэл, цахилгаан	8,008,862.00
2104	Хангамж, бараа материалын зардал	77,455,950.00
210401	Бичиг хэрэг	4,614,100.00
210402	Тээвэр, шатахуун	72,841,850.00
2105	Нормативт зардал	39,998,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	39,998,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,000,000.00
210604	Урсгал засвар	10,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	36,900,000.00
210702	Дотоод албан томилолт	36,900,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,500,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,500,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	96032882.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	96,032,882.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3900000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,900,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,900,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	331226062.43
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	331,226,062.43
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	79,347,572.00
131103	ЗГНХ,ЗДНХхөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	92,310,756.43
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	95,181,600.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	64,386,134.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сүхбаатар аймгийн Эрүүл мэндийн газар Сүхбаатар аймгийн хүн амын эрэлт хэрэгцээнд нийцсэн нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж үйлчилгээг хэнийг ч орхигдуулахгүй тэгш хүртээмжтэй чанартай үзүүлж эрүүл урт наслалт амьдралын чанарыг дээшлүүлэх үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгын хүрээнд эрүүл мэндийн бодлого, удирдлагын үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудит/аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн Эрүүл мэндийн газар 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сүхбаатар аймгийн Эрүүл мэндийн газар нь 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,635,272.2 мянган төгрөгөөр буюу 84.8 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мян.төг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	2,300.0	2,300.0
Авлага	59,582.0	4,201.5	-55,380.5

Бараа материал	368,753.2	296,847.7	-71,905.5
Үндсэн хөрөнгө	1,499,337.8	3,259,596.1	1,760,258.2
Нийт хөрөнгө	1,927,673.1	3,562,945.3	1,635,272.2
Өр төлбөр	0	95,584.3	95,584.3
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,927,673.1	3,467,361.0	1,539,687.9
Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,927,673.1	3,562,945.3	1,635,272.2

- Бараа материал данс 71,905.5 мянган төгрөгөөр буурсан хангамжийн бараа материал өмнөх оноос буурсан нь нөлөөлжээ.
- Авлага данс 55,380.5 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх онд үүссэн ЭМЯ-аас Элэг бүтэн Монгол төслийн санхүүжилт 50,000.0 мянга, мөн вакцины тээврийн зардал 1,151.0 мянга, Аймгийн засаг даргын захирамжаар олгосон Бичигт боомтын цахилгааны засварын үлдэгдэл 8,009.4 төгрөгийн авлага барагдсан нь нөлөөлсөн;
- Үндсэн хөрөнгө данс 1,635,272.2 мянган төгрөгөөр өссөн нь өрхийн эмнэлгийн барилга шинээр ашиглалтад орж, данс бүртгэлд тусгасан нь нөлөөлсөн

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,470,040.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 36,598.7 мянган төгрөгөөр өсгөж, 2,506,539 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь тайлант онд үндсэн цалин хөлс нэмэгдсэнтэй холбоотой төсвийн хуваарьт өөрчлөлт оруулсантай холбоотой юм.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,506,539.7 мянган төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлсэн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,506,539.7 мянган төгрөгийн санхүүжилт олгож, үйл ажиллагааны орлого 150,757.7 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна. Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,355,782.0 мянган төгрөг буюу 94.0 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	80801- Үндсэн үйл ажиллагаа	1,303,389.6	1,291,194.7	12,194.9	99.0%
2	80802- Тэтгэмж урамшуулал	1,191,860.1	1,053,474.4	138,385.7	88.4%
3	83112- Хөтөлбөр дотоод урсгал	11,290.0	11,112.9	177.1	98.4%
	Дүн	2,506,539.6	2,355,782.0	150,757.7	94.0%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд нийт 339,722.5 мянган төгрөгийн санхүүжилт төвлөрсөн бөгөөд үүнд Монголын сумын эмч, мэргэжилтний холбооны Сүрьеэгийн үзлэгийн санхүүжилт, Эрүүл мэндийн байгууллагын тусгай зөвшөөрлийн гэрчилгээний орлого, НҮБ-ын Хүн амын сан, ДЭМБ, ХӨСҮТ, ЭМЯ, аймаг, сумын Засаг даргын тамгын газраас олгосон сургалт, тээвэр, шагнал, ахмадын сангийн санхүүжилтүүд багтсан байна. Жилийн эцсийн байдлаар дансны үлдэгдэл 2,300.0 мянган төгрөг байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд тус байгууллагад гадаадын болон дотоодын төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Эрүүл мэндийн газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, нягтлан бодох бүртгэлтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор А.Мөнхцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Нарантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Г.Даваа нар тус тус хэрэгжүүлсэн.

Эрүүл мэндийн газар нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг ДУНД гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 4,324,724.2 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 64,870.29 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Эрүүл мэндийн газар нь тус хуулийн 15 дугаар зүйлд заасан арга хэмжээг байгууллагын онцлогт тохируулан хэрэгжүүлж байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд 5 сая төгрөгөөс дээш байр ашиглалттай холбогдсон зардлаас бусад тайлант оны өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой гарсан тушаал шийдвэр болон бусад мэдээллийг Шилэн дансны тухай хуулийн дагуу бүрэн мэдээлжээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн бусад хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сүхбаатар аймгийн Эрүүл мэндийн газарт тайлант онд завсрын аудит хийгээгүй.

4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон 2,568.2 мянган төгрөгийн зөрчил арилгуулах 2 албан шаардлага бүрэн хэрэгжиж, 100.0 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	2	2,568.2	2	2,568.2	100
Нийт дүн	2	2,568.2	2	2,568.2	100

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 184,629.2 мянган төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 182,864.0 мянган төгрөгийн алдааг залруулж, алдааг дахин давтан гаргахгүй байх 1,765.2 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 2 зөвлөмж өгсөн.

5.1 Албан шаардлага

Илрүүлэлт-1

Төсвийн гүйцэтгэл, санхүүжилтийг холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлж, тайлагнасны үндсэн дээр аудитын дүгнэлтээр "Өөрчлөлтгүй" үнэлгээ авсан нягтлан бодогчдод 40 хувиар 3 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгосон нь үр дүнгийн урамшуулалтай давхардсанаар төсвийг үр ашиггүй зарцуулж, мөн дээд шатны төсөв захирагчийн хууль, журамд нийцээгүй шийдвэрийг хэрэгжүүлснээр эрх бүхий албан тушаалтны нийтлэг үүргийг зөрчсөн байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2, Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар хуулийн 37.1.6 дэх заалтуудыг зөрчсөн тул зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүллээ.

5.2 Зөвлөмж

Тээвэр шатахууны данстай холбоотой асуудал

5.2.1 Илрүүлэлт

Тээвэр шатахууны зарцуулалтад замын хуудсыг бүрэн, тодорхой, иж бүрэн хөтлөөгүй, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулаагүй, анхан шатны баримтыг стандартын дагуу хөтөлж тайлагнаагүй зөрчил илэрлээ.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 /төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах/, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 /анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно/ хуулийн хэрэгжилтийг бүрэн биелүүлж ажиллах

Дотоод томилолттой холбоотой

5.2.2 Илрүүлэлт

Томилолтын зардлын баримтын бүрдүүлэлтийг шалгахад албан хаагчид томилолтоор ажиллуулах тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр, томилолтоор ажиллуулах удирдамжгүй байх зэрэг зөрчил дутагдал илэрсэн.

Өгсөн зөвлөмж

Албан томилолтыг олгохдоо Засгийн газрын 2019 оны 6 тогтоолын дагуу удирдамж, төлөвлөгөө боловсруулан, төсөв захирагчийн шийдвэр гаргуулж олгож байх.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	/мянган төгрөгөөр/							
	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төсвийн гүйцэтгэл, санхүүжилтийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлэн тайлагнасны үндсэн дээр жилийн эцсийн санхүүгийн тайланд хийгдсэн аудитын дүгнэлтээр "Өөрчлөлтгүй" гэсэн дүгнэлт авсан тус байгууллагын нягтлан бодогчид 40 хувиар 3 сарын мөнгөн урамшуулал олгосон	1	1,765.2			1	1,765.2		
Тээвэр шатахууны зарцуулалтад замын хуудсыг бүрэн, тодорхой, иж бүрэн хөтлөөгүй, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулаагүй, анхан шатны баримтыг стандартын дагуу хөтөлж тайлагнаагүй зөрчил илэрлээ.	1						1	
Томилолтын зардлын баримтын бүрдүүлэлтийг шалгахад албан хаагчид томилолтоор ажиллуулах тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр, томилолтоор ажиллуулах удирдамжгүй байх зэрэг зөрчил дутагдал илэрсэн.	1	0					1	0
Дүн	3	1,765.2			1	0	2	1,765.2

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн бүртгэлийн маагт

Аудитын код: СБА-2024/070/НА-СТА-ТШЗ

Аудитын нэр: Санхүүгийн тайлангийн аудит

Байгууллагын нэр: Эрүүл мэндийн газар

Аудитын чиглэл/ өсүүлт		Алдаа, зөрчлийн товч утга		Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Шалгардагч байгууллагын санал, тайлбар	Гаргасан шийдвэр
№		1	2				
A				3	4	5	6
1	Мөнгөн хөрөнгө	Сүхбаатар аймгийн ЗМГ-ын даргын 2024.07.03-ны өдрийн А/45 тоот тушаалаар байгууллагын нягтлан бодогчид балансын урамшуулал 40 хувиар 3 сарын хугацаагаар олгогдсон бөгөөд энэ нь Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтад заасан гүйцэтгэлийн үнэлгээ, ажлын үр дүнг үнэлэн улирал бүр олгосон мөнгөн урамшуулалтай давхцсан нь давхар урамшуулал олгох эрсдэл үүсгэж, төсвийн мөнгийг зохистой зарцуулахад сөрөг нөлөө үзүүлэхээр байна.					
2	Тээвэр шатахуун	Тээвэр шатахууны зарцуулалтад замын хуудсыг бүрэн, тодорхой, их бүрэн хөтлөөгүй, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулаагүй, анхан шатны баримтыг стандартын дагуу хөтөлж тайлагнаагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 /төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах/, 41.2.3 дахь заалтыг нэмэх болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 /анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно/ заалттай нийцэхгүй байгааг харуулж байна.					
3	Томилолт	Томилолтын зардлын баримтын бүрдүүлэлтийг шалгахад албан хаагчид томилолтоор ажиллуулах тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр, томилолтоор ажиллуулах удирдамжгүй байх зэрэг зөрчил дутагдал илэрсэн.					
4	Бараа материал	Барилгын засварын материал дансанд эм, эмнэлгийн хэрэгсэл бүртгэж бараа материалын тайланг үнэн зөв бэлтгэж толилуулаагүй зөрчил дутагдал илэрсэн.					
			Нийт дүн	182,864.0	Залруулсан алдаа	Хүлээн зөвшөөрсөн	Залруулсан алдаа
				184,629.2			

Танилцаж зөвшөөрсөн:

Бэлтгэсэн: Аудитор
Анхан шатны хянасан: Аудитын менежер
Хоёр дахь шатанд хянасан: Дарга, Тэргүүлэх аудитор

Хүлээн зөвшөөрсөн:
Эрүүл мэндийн газрын дарга
Нягтлан бодогч:

Хүлээн зөвшөөрсөн:

Хүлээн зөвшөөрсөн:

2217144021
ЛХСА0042 9054561



СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

6 давхарт, Нутгийн удирдлагын 2 дугаар байр,
Балдан-Осорын гудамж, 7 дугаар баг,
Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг, 22075
Утас: (976) 70518396
Цахим шуудан: sukhbaatar@audit.gov.mn

2025.02.25 № 126
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрүүл мэндийн газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд өрхийн эмнэлгийн барилга ашиглалтад орж, тээврийн хэрэгсэл нэмэгдсэнээр үндсэн хөрөнгө 1,760,258.2 мянган төгрөгөөр буюу 2.2 дахин өссөн бөгөөд энэ нь иргэдэд эрүүл мэндийн үйлчилгээг хүртээмжтэй, тав тухтай орчинд хүргэх боломжийг бүрдүүлж, салбарын дэд бүтцийн хөгжилд эерэг нөлөө үзүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Барилгын засварын дансанд тусгай зориулалтын материалыг буруу ангилан бүртгэсэн зөрчлийг илрүүлж, холбогдох журам болон стандартад нийцүүлэн залруулж, зөв ангилалд бүртгүүлэн, санхүүгийн тайлангийн үр нөлөөг дээшлүүлсэн.

Бусад асуудал

“Эрүүл мэндийн үйлчилгээнд тавигдах шаардлага” MNS 7014:2023 стандартыг эрүүл мэндийн байгууллага бүрд хэвшүүлэх, сурталчлах зорилгоор 9 удаагийн сургалт зохион байгуулж 19 байгууллагын давхардсан тоогоор 511 эмч эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан хамрагдсан.

Тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ДАВАА



СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 35 А1770381

Баруун-Урт сум

СБА-2025/070/1А-СТА-ТЦЦ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сүхбаатар аймгийн Эрүүл мэндийн газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Санхүүгийн ажилтанд 1,765.2 мянган төгрөгийн балансын урамшуулал олгосон нь үр дүнгийн урамшуулалтай давхардуулсан зөрчилтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлтийн 16.5.5 (батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;), 41 дүгээр зүйлийн 41.2.2 (батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах;), 41.2 дахь хэсгийн 41.2.3 (төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах;), Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам", 2023 оны 301 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам"-ыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Санхүүгийн ажилтанд үр дүнгийн болон балансын урамшууллыг давхардуулан олгосон зөрчлийг таслан зогсоож, төсвийг арвилан хэмнэлт, үр ашигтай захиран зарцуулж, биелэлтийг 2025 оны 05 дугаар сарын 30-ны дотор Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газар¹-т ирүүлэх

2. Алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомж, журам зааврыг мөрдөж ажиллахыг Эрүүл мэндийн газрын дарга (М.Дэлхийцэцэг)-т даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Т.ДАВАА

АУДИТОР  А.МӨНХЦЭЦЭГ